

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2024/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2024 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.23 № 251

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, үйл явдал гараагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 7 зорилтын хүрээнд 138 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 92.1 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011021107

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,339,835.60	325,440,320.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	144,339,835.60	325,440,320.00
354	Хангамжийн материал	131,720,835.60	308,930,320.00
35410	Бичиг хэргийн материал	205,943.60	-
35420	Аж ахуйн материал	131,514,892.00	308,930,320.00
35600	Мал амьтад	12,619,000.00	16,510,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,945,275,675.47	10,533,138,332.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,945,275,675.47	10,533,138,332.50
392	Биет хөрөнгө	7,445,275,675.47	10,033,138,332.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	469,911,800.00	9,600,311,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(456,721,824.73)	(457,182,119.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,170,000.00	316,070,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,712,708.29)	(29,880,208.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	449,471,800.00	755,368,205.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,428,993.14)	(331,732,748.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	181,893,947.00	296,187,597.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,234,296.37)	(116,004,193.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,656,850.00	26,656,850.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,656,850.00)	(26,656,850.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,040,925,951.00	-
393	Биет бус хөрөнгө	500,000,000.00	500,000,000.00
39301	Програм хангамж	121,859,618.94	121,859,618.94
39302	Хуримтлагдсан элэгдэл	(121,859,618.94)	(121,859,618.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	500,000,000.00	500,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,089,615,511.07	10,858,578,652.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,089,615,511.07	10,858,578,652.50
51	Засгийн газрын хувь оролцоо	8,089,615,511.07	10,858,578,652.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,124,330,743.83	2,124,330,743.83
51101	Өмч: - төрийн	2,124,330,743.83	2,124,330,743.83
512	Хуримтлагдсан үр дүн	5,945,440,405.04	8,714,403,546.47
51210	Өмнөх үеийн үр дүн	3,600,619,524.76	5,945,440,405.04
51220	Тайлант үеийн үр дүн	2,344,820,880.28	2,768,963,141.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,844,362.20	19,844,362.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,089,615,511.07	10,858,578,652.50

**Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,970,081,057.0	16,966,179,335.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,757,399,955.0	10,956,004,138.5
120	Нийтлэг татварын бус орлого	2,757,399,955.0	10,956,004,138.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,757,399,955.0	10,956,004,138.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,317,990.0	31,097,775.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000,000.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,430,081,965.0	10,924,906,363.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	6,212,681,102.0	6,010,175,197.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,746,259,602.0	667,614,797.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000,000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,165,731,784.0	283,452,993.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	380,148,838.0	384,161,804.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	378,980.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,466,421,500.0	5,342,560,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,958,932,500.0	4,829,776,200.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	507,489,000.0	512,784,200.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,551,468,158.7	14,197,216,194.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,551,468,158.7	14,197,216,194.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,930,441,213.9	12,162,446,600.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,123,397,193.3	1,859,629,282.8
210101	Үндсэн цалин	479,799,693.8	747,787,139.0
210102	Нэмэгдэл	195,195,232.1	484,344,588.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,812,356.9	47,720,842.6
210104	Урамшуулал	50,268,825.2	62,565,729.3
210105	Гэрээт ажлын хөлс	321,321,085.4	517,210,983.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,656,002.0	230,116,617.9
210201	Тэтгэврийн даатгал	88,889,865.2	156,345,974.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,980,741.7	18,971,299.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,139,816.1	15,176,999.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,985,017.6	3,355,580.6
210205	Эрүүл мэндийн даатгал	21,660,561.4	36,266,764.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,087,485.0	90,659,462.7
210301	Гэрэл, цахилгаан	8,998,076.0	20,125,350.9
210302	Түлш, халаалт	18,652,558.0	38,829,533.6
210303	Цэвэр, бохир ус	9,096,851.0	14,704,578.2
210304	Байрны түрээс	17,340,000.0	17,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	139,489,060.0	237,861,535.7
210401	Бичиг хэрэг	44,774,050.0	49,799,695.0
210402	Тээвэр, шатахуун	48,755,100.0	69,891,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,341,010.0	12,633,465.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,618,900.0	65,227,210.0
210408	Бараа материал акталсны зардал	-	40,309,565.6
2105	Нормативт зардал	1,500,000.0	1,500,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,296,800.0	45,068,020.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,958,500.0
210604	Урсгал засвар	62,296,800.0	42,109,520.0
2107	Томилголт, зочны зардал	85,417,980.0	95,500,400.0
210702	Дотоод албан томилолт	85,417,980.0	95,500,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,819,206.0	157,733,765.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,364,740.0	141,909,900.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,577,100.0	11,596,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	688,466.0	49,340.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	248,900.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.0	1,378,000.0
210807	Газрын төлбөр	1,440,000.0	2,800,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,194,777,487.7	9,444,377,516.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,035,184,281.0	9,208,260,226.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,407,740.0	50,442,550.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,185,466.7	185,674,740.0
211	ХҮҮ	1,795,691,200.0	1,858,364,600.0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,795,691,200.0	1,858,364,600.0
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,795,691,200.0	1,858,364,600.0

**Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	825,335,744.7	176,404,993.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,062,100.0	11,155,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,035,000.0	11,155,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,027,100.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	592,820,676.7	163,913,475.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	592,820,676.7	163,913,475.0
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	208,452,968.0	1,336,518.6
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	208,452,968.0	1,336,518.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,418,612,898.4	2,768,963,141.4
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,792,018.1	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	73,792,018.1	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(73,792,018.1)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,344,820,880.3	2,768,963,141.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,539,999,092.00	6,041,272,972.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	327,317,990.00	31,097,775.00
120	Нийтлэг татварын бус орлого	327,317,990.00	31,097,775.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	327,317,990.00	31,097,775.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,317,990.00	31,097,775.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,212,681,102.00	6,010,175,197.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,746,259,602.00	667,614,797.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,165,731,784.00	283,452,993.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	380,148,838.00	384,161,804.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	378,980.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,466,421,500.00	5,342,560,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,958,932,500.00	4,829,776,200.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	507,489,000.00	512,784,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,435,826,092.00	6,041,272,972.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,435,826,092.00	6,041,272,972.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,814,799,147.27	4,006,503,378.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,123,397,193.27	1,859,629,282.80
210101	Үндсэн цалин	479,799,693.75	747,787,138.98
210102	Нэмэгдэл	195,195,232.05	484,344,588.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,812,356.86	47,720,842.62
210104	Урамшуулал	50,268,825.18	62,565,729.28
210105	Гэрээт ажлын хөлс	321,321,085.43	517,210,983.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,656,002.00	230,116,617.85
210201	Тэтгэврийн даатгал	88,889,865.24	156,345,974.02
210202	Тэтгэмжийн даатгал	9,980,741.69	18,971,299.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,139,816.14	15,176,999.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,985,017.55	3,355,580.59
210205	Эрүүл мэндийн даатгал	21,660,561.38	36,266,764.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,087,485.00	90,659,462.65
210301	Гэрэл, цахилгаан	8,998,076.00	20,125,350.89
210302	Түлш, халаалт	18,652,558.00	38,829,533.56
210303	Цэвэр, бохир ус	9,096,851.00	14,704,578.20
210304	Байрны түрээс	17,340,000.00	17,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,401,360.00	191,066,070.13
210401	Бичиг хэрэг	44,774,050.00	49,799,695.00
210402	Тээвэр, шатахуун	48,755,100.00	69,891,600.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	14,341,010.00	12,633,465.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,531,200.00	58,741,310.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00

**Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		82,291,700.00	67,251,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		19,994,900.00	23,796,400.00
210604	Урсгал засвар		62,296,800.00	43,455,420.00
2107	Томилголт, зочны зардал		85,417,980.00	95,500,400.00
210702	Дотоод албан томилголт		85,417,980.00	95,500,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		144,818,206.00	200,369,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		137,363,740.00	184,545,950.00
210803	Даатгалын үйлчилгээ		3,577,100.00	11,596,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		688,466.00	49,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		248,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,500,000.00	1,378,000.00
210807	Газрын төлбөр		1,440,000.00	2,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,052,229,221.00	1,270,409,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,031,821,481.00	1,219,967,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		20,407,740.00	50,442,550.00
211	ХҮҮ		1,795,691,200.00	1,858,364,600.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		1,795,691,200.00	1,858,364,600.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		1,795,691,200.00	1,858,364,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		825,335,744.73	176,404,993.57
2132	Бусад урсгал шилжүүлэг		24,062,100.00	11,155,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		3,035,000.00	11,155,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		21,027,100.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		801,273,644.73	165,249,993.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		592,820,676.73	163,913,474.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэг шилжүүлэг		208,452,968.00	1,336,518.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		104,173,000.00	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		104,173,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		104,173,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр		104,173,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		104,173,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(104,173,000.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	3,600,619,524.76	0.00	5,744,794,630.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	3,600,619,524.76	0.00	5,744,794,630.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,344,820,880.28	0.00	2,344,820,880.28
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	5,945,440,405.04	0.00	8,089,615,511.07
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	5,945,440,405.04	0.00	8,089,615,511.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	5,945,440,405.04	0.00	8,089,615,511.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,768,963,141.43	0.00	2,768,963,141.43
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,124,330,743.83	19,844,362.20	8,714,403,546.47	0.00	10,858,578,652.50

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,362,560,400.0	5,209,744,700.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,362,560,400.0	5,209,744,700.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,464,447,900.0	3,340,225,100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,839,307,300.0	1,837,681,752.0
210101	Үндсэн цалин	732,525,100.0	747,787,139.0
210102	Нэмэгдэл	406,822,200.0	484,344,588.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,000,000.0	47,720,842.6
210104	Урамшуулал	127,000,000.0	62,565,729.3
210105	Гэрээг ажлын хөлс	495,960,000.0	495,263,453.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,958,400.0	227,803,943.3
210201	Тэтгэврийн даатгал	154,033,300.0	154,033,299.4
210202	Тэтгэмжийн даатгал	18,971,300.0	18,971,299.2
210203	УОМШӨ-ний даатгал	15,217,000.0	15,176,999.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,794,300.0	3,355,580.6
210205	Эрүүл мэндийн даатгал	37,942,500.0	36,266,764.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,000,000.0	90,659,462.7
210301	Гэрэл, цахилгаан	40,123,000.0	20,125,350.9
210302	Түлш, халаалт	44,727,000.0	38,829,533.6
210303	Цэвэр, бохир ус	30,150,000.0	14,704,578.2
210304	Байрны түрээс	17,000,000.0	17,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	202,127,600.0	191,066,070.1
210401	Бичиг хэрэг	49,500,000.0	49,799,695.0
210402	Тээвэр, шатахуун	66,627,600.0	69,891,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,500,000.0	12,633,465.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,500,000.0	58,741,310.0
2105	Нормативт зардал	1,500,000.0	1,500,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,531,600.0	67,251,820.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,000,000.0	23,796,400.0
210604	Урсгал засвар	43,531,600.0	43,455,420.0
2107	Томилолт, зочны зардал	95,500,400.0	95,500,400.0
210702	Дотоод албан томилолт	95,500,400.0	95,500,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	202,100,200.0	200,369,815.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,850,200.0	184,545,950.0
210803	Даатгалын үйлчилгээ	5,000,000.0	11,596,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.0	49,340.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.0	1,378,000.0
210807	Газрын төлбөр	9,800,000.0	2,800,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	694,422,400.0	628,391,837.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	676,964,200.0	610,934,137.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,458,200.0	17,457,700.0
211	ХҮҮ	1,858,364,600.0	1,858,364,600.0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,858,364,600.0	1,858,364,600.0
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,858,364,600.0	1,858,364,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,747,900.0	11,155,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,747,900.0	11,155,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,000,000.0	11,155,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,747,900.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,342,560,400.0	5,342,560,400.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,342,560,400.0	5,342,560,400.0
122005	Орон нутгийн төсвөөс	5,342,560,400.0	5,342,560,400.0

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	666,278,278.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666,278,278.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,278,278.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,947,530.79
210105	Гэрээт ажлын хөлс	21,947,530.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,312,674.60
210201	Тэтгэврийн даатгал	2,312,674.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	642,018,073.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	609,033,223.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,984,850.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	667,614,796.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,614,796.99
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	283,452,992.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	384,161,804.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/184 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 6,551.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 65.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 14,197.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 142.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох нь зохиомжтой гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалтыг хэрэгжилтийг шалгахад Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй авто машинуудын дугаарын дэвсгэрийг тод өнгөтэй болгож өөрчлөөгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн “7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.” гэсэн заалтын дагуу ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-тэй тулган шалгахад тайлант онд шинээр ашиглалтад орсон нутгийн удирдлагын ордны Засаг даргын тамгын газрын эрхэлсэн түшмэл болон ахлах түшмэл тэдгээртэй адилтгах албан тушаалтнуудын ажлын өрөө нийтлэг жишгээс давсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “5.3.Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.”, “5.4.Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй Засаг даргын орон тооны зөвлөх томилон ажиллуулж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлсэн эсэхийг тулган шалгасан. Цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд ЗГ-ын 2021 оны 377 дугаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолын 3 дугаар хэсэгт “Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 57 хүртэл”, Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар аймгийн Тамгын газрын бүтцийг аймгийн захиргаа удирдлагын бүтэц 3, Тамгын газрын бүтэц 53, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга 1, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагчдын бүтэц 20 албан

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хаагчтай байхаар баталсан байна. Тайлант хугацаанд бодит гүйцэтгэлээр 83-88 албан хаагч буюу Засаг даргын баталсан орон тооноос 11 албан хаагч илүү цалинжуулж ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 3,290.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд 3,115.0 мянган төгрөгийн албан шаардлага, 175.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100
Төлбөрийн акт	1	5,607.4	1	5,607.4	100
Албан шаардлага	2	750.9	2	750.9	100
Нийт дүн	4	6,358.4	4	6,358.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Засаг даргын Тамгын газрын орон тооны асуудлыг анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 81,096.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 56,463.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,678.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 16,954.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж бичив.

5.1 Төлбөрийн акт

Төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл 56,463.6 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай журмын 4-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн Засаг даргын 2023 оны Б/09 дугаартай захирамжаар зөвлөх томилж ажиллуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно”, 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно”, мөн ЗГ-ын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаар тогтоох тухай” тогтоолтой нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант хугацааны бодит гүйцэтгэлээр 83-88 албан хаагчийг цалинжуулж 11 орон тоогоор илүү ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газар нь цахим дэлгүүрт байршаагүй 16,587.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орон нутгийн аж ахуйн нэгжээс худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.”, “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийж ажиллах.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 5 авто машины улсын дугаарын дэвсгэрийг тод дэвсгэртэй болгож өөрчлөөгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгслийн улсын дугаар тэмдэгтийн MNS4410-1:2002 стандартад нийцүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТҮ албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон	1	56,463.6	1	56,463.6	-	-	-	-	-	-	-	-	-
Зөвлөх томилсон	1	7,678.2	-	-	1	7,678.2	-	-	-	-	-	-	-
Орон хэтрүүлэн ажилласан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Хоолны мөнгө чөлөөтэй байх хугацаанд суутгаагүй	1	175.0	1	175.0	-	-	-	-	-	-	-	-	-
Малын төлийн орлого бүртгээгүй	1	3,115.0	-	-	1	3,115.0	-	-	-	-	-	-	-
Төрийн албаны 39.1.3-т заасныг зөрчсөн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	6	67,431.8	2	56,638.6	4	10,793.2	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.	1	0	-	-	-	-	1	0
Дүн	1	0	-	-	-	-	1	0
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Авто машины дугаарын дэвсгэр солиогүй	1						1	
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	16,587.9					1	16,587.9
Дүн	2	16,587.9	-	-	-	-	2	16,587.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	3	16,587.9	-	-	-	-	3	16,587.9



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 09 ДДА-2024/95/НА-СГГ-ТШС АНХБСОГ Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл нийт 56,463,601 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 4-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно." гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;" 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэмэгдэл цалинд олгосон 56,463,601 /тавин зургаан сая дөрвөн зуун жаран гурван мянга зургаан зуун нэг/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн хүү, торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

011050261

2. Актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 18 ДСН 2024/02/НА-СТА 7413 21170309
Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2023 оны Б/09 дугаартай захирамжаар Засаг дарга өөртөө үйлчлэх орон тооны зөвлөх томилж ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", 5.4-д "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөвлөх авч ажиллуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ



011041010



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 19 ДСА-2024/01/МА-СТБ-0123 АНГДСОГ
Чойбалсан хот

Г

Г

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаартай захирамжаар баталсан орон тоог хэтрүүлэн 11 албан хаагч цалинжуулж ажилласан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 3 дугаар хэсэгт "Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээгээс хамааруулан Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 57 хүртэл", Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар аймгийн Тамгын газрын бүтцийг аймгийн захиргаа удирдлагын бүтэц 3, Тамгын газрын бүтэц 53, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга 1, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагчдын бүтэц 20 албан хаагчтай байхаар баталсантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

3. Батлагдсан орон тооноос хэтрүүлэн ажиллаж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АУДИТОР  М.УХААНБИЛЭГ

011041000



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 71 ДДА-2024/93/НА-СА-7113 Чойбалсан хот
АМТ0307

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын 3.12-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын зарим албан хаагчдад цалинтай чөлөөтэй байх хугацаанд хоолны мөнгө олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалинтай чөлөөтэй байх хугацаанд олгосон хоолны мөнгө болох 175,000 /Нэг зуун далан таван мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ



011050178



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 02/2023 ДДН/2024/03/М-СА-1013 Чойбалсан хот
2170309

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ газар нь туслах аж ахуйн 3.1 сая төгрөгийн малын төлийг санхүүгийн тайланд орлогоор бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Туслах үйл ажиллагааны төл малын 3,115,000 /Гурван сая нэг зуун арван таван мянган/ төгрөгийг орлогод бүртгэх, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч П.Чимигсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ



011040800



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 01/2023 ДСН-2024/03/НА-СНА-2023

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 4 сарын турш чөлөөтэй байна. Мөн ЗДТГ-ын дарга 2023 оны Б/68 дугаар тушаалаар уг ахлах мэргэжилтэнд чөлөө олгохдоо дуусах хугацаагүй чөлөө олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн "39.1.3.хуульд нийцээгүй шийдвэр гаргах;" 41 дүгээр зүйлийн 43 дугаар зүйлийн "43.3.4.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх.", 46 дугаар зүйлийн "46.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлнө:" гэсний "46.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 3 сараас дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн ахлах мэргэжилтний урт хугацааны чөлөөтэй байгаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж,

011040801

биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзий-д хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

М.УХААНБИЛЭГ

